



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/155

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх Ховд аймгийн Булган сумын Баянсудал багт үндэсний үйлдвэрлэлийн автобус нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Б.Батнасан - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Нямжаргал - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Д.Батсайхан - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Г.Нэмэхбаяр - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Г.Нэмэхбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ

Zax A/155 Ch
02 00743